



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР

СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

2016 он



ӨМНӨХ ҮГ

Улиран одсон 2016 онд Монгол улсын Иргэний нисэхийн салбарт олон улсын зорчигч урсгал 3,2, орон нутгийн зорчигч 22,5 хувиар өссөн бол ачаа, шуудан олон улсад 3, орон нутагт 14, хөөрөлт, буултын тоо 10 хувиар тус тус өслөө. Түүнчлэн, нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулж үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн үйлчилгээг нэвтрүүлснээр өнгөрөлтийн нислэгийн орлогыг нэмэгдүүлж чадсан.

Дэлхий дахинаа Монгол Улсын нэр хүндийг өргөсөн түүхэн үйл явдал болох Ази-Европын төрийн дээд хэмжээний чуулга уулзалт зохион байгуулагдаж Иргэний нисэхийн салбар өндөр ачаалалтай, хариуцлагатай ажиллаа.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2017 оны наймдугаар сард Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази-Номхон далайн бүсийн орнуудын иргэний нисэхийн Ерөнхий захирлуудын 54 дүгээр



хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна.

Түүнчлэн, Хөшигийн хөндийд баригдсан шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хийж байна.

2016 онд Монгол улсын Иргэний нисэхийн салбарт өрнөсөн үйл явдал, хөрөнгө оруулалт, шинэчлэл, үйл ажиллагаа, хамт олны хөдөлмөр, зүтгэл, хөгжлийг тоон үзүүлэлтэд тулгуурлан мэдээлдэг “Статистикийн эмхэтгэл”-ээ та бүхэнд хүргэж байна.

Хүндэтгэсэн,
Л.Бямбасүрэн
ИНЕГ-ын дарга

АГУУЛГА

- 1 МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- 2 ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
- 3 ДЭЛХИЙН АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТОЙМ
- 4 ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ
- 5 ОРОН НУТГИЙН АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ
- 6 АГААРЫН ТЭЭВРИЙН ӨНӨӨГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
- 7 ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ
- 8 НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ
- 9 АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- 10 АГААРЫН ХӨЛГИЙН ШАТАХУУН
- 11 ТӨСӨӨЛӨЛ
- 12 ХҮСНЭГТҮҮД



зорчигч урсгал

ОЛОН УЛС

2015 он



765,924

2016 он



790,459



ӨСӨЛТ
3.2%



ОРОН НУТАГ

2015 он



189,943

2016 он



232,586

Хуваарьт
123,014

Захиалгат
66,929

Хуваарьт
148,307

Захиалгат
84,279



ӨСӨЛТ
21%



ӨСӨЛТ
26%

ачаа тээвэр

ОЛОН УЛС

2015 он



4,178 тонн

2016 он



4,363 тонн



ӨСӨЛТ
4%



ОРОН НУТАГ

2015 он



34 тонн

2016 он



46 тонн



ӨСӨЛТ
34%



шуудан

ОЛОН УЛС

2015 он



421 тонн

2016 он



360 тонн



Бууралт
-15%



ОРОН НУТАГ

2015 он



77 тонн

2016 он



83 тонн



ӨСӨЛТ
8%



Post box 17120 Chinggis Khaan International Airport | Khan-Uul district,
10th khoroo | Buyant-Ukhaa | Ulaanbaatar, Mongolia <http://www.mcaa.gov.mn>




МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тээврийн салбар нь өргөн удам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын хувьд эдийн засагт чухал ач холбогдолтой салбарын нэг юм. Манай улсад авто, төмөр зам, агаар, усан замын үндсэн 4 төрлийн тээврийн дэд салбарууд үйл ажиллагаа явуулж байна. Тээврийн салбарын хэмжээнд 2016 онд нийт 264 сая зорчигч, 40,3 мянган тонн ачаа тээвэрлэж, ачаа эргэлт 16,441 сая тонн километр, зорчигч эргэлт 4,069 сая километр зорчигчид хүрсэн үзүүлэлттэй байна.

Салбарын хэмжээнд 2015 онд нийт тээвэрлэлтийн үзүүлэлт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байсан бол 2016 онд нийт үзүүлэлт өссөн бөгөөд зорчигч тээвэрлэлт өмнөх оноос 2 хувиар, ачаа тээвэрлэлт 13 хувиар мөн зорчигч эргэлт 0,2 хувиар, ачаа эргэлт 12 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

График 1-1: Монгол улсын нийт тээврийн салбарын 2010-2016 оны статистикийн үзүүлэлтүүд




(Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо)

ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2016 онд нийт 1,023,045 зорчигч тээвэрлэснээс олон улсын чиглэлд 790,459 зорчигч, орон нутгийн чиглэлд 232,586 зорчигч тээвэрлэсэн байна. Олон улсын чиглэлд тээвэрлэсэн зорчигчийн тоо өмнөх оноос 3,2 хувиар буюу 24,5 мянган зорчигчоор өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд Монгол улсын олон улсын агаарын тээврийн зах зээлд “Эйр Бусан” шинээр нэмэгдэж, Улаанбаатар-Бусан-Улаанбаатар чиглэлд, мөн “Хүннү Эйр” ХХК Улаанбаатар-Бугат-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэж эхэлсэн нь олон улсын зорчигч тээвэрлэлтийн өсөлтөд нөлөөлсөн.

Орон нутгийн зорчигчийн тоо өмнөх оноос 22,5 хувиар буюу 42,6 мянган зорчигчоор өссөн байна. Орон нутгийн зорчигч тээвэрлэлт өссөн хэдий ч нийт зорчигчийн 52,8 хувийг уул уурхайн чиглэлийн захиалгат нислэгийн зорчигч тээвэрлэлт эзэлж байна. Үүнээс үзэхэд уул уурхайн салбарын өсөлтөөс орон нутгийн зорчигч тээвэрлэлт өссөн үзүүлэлттэй байна.


График 2-2: Тээвэрлэсэн зорчигч /2006-2016 он/






Салбарын хэмжээнд тээвэрлэсэн нийт ачаа 4,409 тоннд хүрч өмнөх оноос 5 хувиар өсөж, тээвэрлэсэн ачааны сүүлийн 10 жилийн дундаж өсөлт 4,9 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт тээвэрлэсэн ачааны 4,363 тонн буюу 98 хувийг олон улсын ачаа тээвэрлэлт, 46 тонн буюу 2 хувийг орон нутгийн ачаа тээвэрлэлт эзэлж байна.

График 2-3: Тээвэрлэсэн ачаа /2006-2016 он/



Нийт тээвэрлэсэн шуудан өмнөх оноос 11 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт шуудан тээвэрлэлтийн 360 тонн буюу 81 хувийг олон улсын шуудан тээвэрлэлт, 83 тонн буюу 19 хувийг орон нутгийн шуудан тээвэрлэлт эзэлж байна.

График 2-4: Тээвэрлэсэн шуудан /2006-2016 он/



Монгол Улсын агаарын зайгаар 2016 онд өнгөрөлтийн нислэг нийт 99,210, олон улсын хөөрөлт , буулт нийт 6,726, орон нутгийн хөөрөлт, буулт нийт 4,956 үйлдэгдсэн ба өнгөрөлтийн нислэгийн тоо өмнөх оноос 9.4 хувиар өсөж, олон улсын хөөрөлт, буулт өмнөх оноос 4.6 хувиар, орон нутгийн хөөрөлт, буулт 8.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна

График 2-5: Буулт хөөрөлт /2012-2016 он/





График 2-6: Өнгөрөлтийн нислэг /2012-2016 он/






24,775 ТОНН




Олон улсад гадаад дотоодын
8-н агаарын тээвэрлэгч
нислэг үйлдсэн



2430

ИНЕГ-ЫН НИЙТ
АЖИЛЧДЫН ТОО



Том оврын агаарын хөлөг 5



Дунд оврын агаарын хөлөг 6



Бага оврын агаарын хөлөг 13



24

Нислэгт тэнцэх
чадварын гэрчилгээтэй
агаарын хөлгийн тоо



ИРГЭНИЙ НИСЭХИЙН МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ЭЗЭМШИГЧИД



НИСГЭГЧ

125

Үүнээс:

МИАТ 49

АЭРОМОНГОЛИА 28

ХУННУ ЭЙР 20

ИНЕГ 4

ЕРӨНХИЙ
ЗОРИУЛАЛТЫН
АГААРЫН
ТЭЭВЭРЛЭГЧИД 17ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН
АЖИЛЧИД

367

Үүнээс:

181

23

46

14

14

НИСЛЭГИЙН
УДИРДАГЧ

188



ОПЕРАТОР

58

Идэвхигүй
байгаа:

НИСГЭГЧ

7

ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН
АЖИЛЧИД

89



Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба

Иргэний нисэхийн ерөнхий газрын, нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газраас гэрчилгээжсэн мэргэжлийн үнэмлэх эзэмшигчид 738 байна. Монгол Улсын иргэний агаарын хөлгийн бүртгэлд нийт агаарын хөлөг бүртгэлтэйгээс нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй нийт 24 агаарын хөлөг бүхий агаарын тээвэрлэгч үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2-1: Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгийн тоо /2016 он/

№	Агаарын тээвэрлэгчийн нэр	Агаарын хөлгийн тоо
1	"МИАТ" ХК	5
2	"Аэромонголиа" ХХК	2
3	"Хүннү Эйр" ХХК	2
4	"МАК" ХХК	2
5	"А-Жет Авиэйшн" ХХК	2
6	"Блу Скай Авиэйшн" ХХК	1
7	"Геосан" ХХК	2
8	"Томас Эйр" ХХК	2
9	"Вильтал Авиа" ХХК	1
10	"Топ Экстрим" ХХК	5
Нийт		24

Тайлбар: "МИАТ" ХК-ийн 2 ширхэг В-737, 1 ширхэг В-767 нийт 3 ширхэг агаарын хөлөг Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газраас гэрчилгээждэггүй болно. Мөн "Топ Экстрим" ХХК-ийн 5 ширхэг агаарын хөлөг хувь хүн эзэмшдэг. "А-Жет Авиэйшн" ХХК-ийн 2 ширхэг EC145 MBV BK 117-C2 агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа дууссан, шинээр аваагүй байгаа болно.



ДЭЛХИЙН АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТОЙМ

Дэлхийн хэмжээнд хуваарьт нислэгээр гүйцэтгэсэн зорчигч километр өмнөх оноос 5,9 хувиар, боломжит суудал километр 6,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 3-1: Боломжит суудал километр /Бүс нутгаар/-2016/2015 он





График 3-2: Гүйцэтгэсэн зорчигч километр /Бүс нутгаар/-2016/2015 он



(Эх сурвалж: ICAO, IATA)

ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын агаарын тээврийн хувьд 2016 онд дотоодын 3 агаарын тээвэрлэгч/ “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК, гадаадын 5 агаарын тээвэрлэгч “Кореан Эйр”, “Эйр Чайна”, “Аэрофлот”, “Туркиш Эйрлайнс”, “Эйр Бусан” зэрэг агаарын тээвэрлэгчид / Бээжин, Токио, Сөүл, Хонгконг, Москва, Берлин, Франкфурт, Бусан, Хөх хот, Эрхүү, Хайлаар, Манжуур, Эрээн, Бугат, Бишкек, Станбул, Бусан зэрэг нийт 17 чиглэлд хуваарьт, болон хуваарьт бус нислэг үйлдсэн.

Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК нь Бээжин, Сөүл, Москва, Токио, Хонгконг, Берлин, Франкфурт чиглэлд хуваарьт нислэг үйлдсэн бол “Аэромонголиа” ХХК Хөх хот болон Эрхүү чиглэлд, “Хүннү Эйр” ХХК Хайлаар, Манжуур, Эрээн, Бугат чиглэлд хуваарьт болон хуваарьт бус нислэг тус тус үйлдээд байна.


Агаарын тээвэрлэгчдийн олон улсын нислэгийн чиглэл /2016 он/



Тайлбар: Улирлын хамаарлаас шалтгаалсан зорчигч урсгалын улмаас Франкфуртын нислэг 2016 онд 6 дугаар сараас 9 дугаар сар хүртэл, Хайлаарын нислэг 1 дүгээр сараас 5 дугаар сар хүртэл, Эрээн хотын нислэг 8 дугаар сараас 10 дугаар сар хүртэл тус тус нислэг үйлдсэн байна.

Дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгчид нь 2016 онд олон улсын чиглэлд нийт 790,459 зорчигч тээвэрлэсэн бөгөөд үүнээс “МИАТ” ХК нийт зорчигч тээвэрлэлтийн 50 хувийг, “Аэромонголиа” ХХК 2 хувийг, “Хүннү Эйр” ХХК 2 хувийг, “Кореан Эйр” 20 хувийг, “Эйр Чайна” 12 хувийг, “Туркиш Эйрлайнс” 5 хувийг, “Аэрофлот” 6 хувийг, “Эйр Бусан” 2 хувийг, гадаадын агаарын тээвэрлэгчдийн захиалгат нислэг 1 хувийг тус тус тээвэрлэсэн байна. 2016 онд Монгол улсын олон улсын агаарын тээврийн зах зээлд “Эйр Бусан” шинээр нэмэгдэж, Бусан-Улаанбаатар -Бусан чиглэлд нислэг үйлдэж эхлээд байна.

График 4-1 : Олон улсын агаарын тээврийн зах зээл /агаарын тээвэрлэгч тус бүрээр/



Олон улсын чиглэлд тээвэрлэсэн нийт зорчигчийн тоо 2010 оноос 2012 он хүртэл жилд дунджаар 19 хувийн өсөлттэй байсан. Харин 2012 оноос эхлэн олон улсын чиглэлд тээвэрлэсэн зорчигчийн тоо тогтворжиж, 2016 онд нийт зорчигчийн тоо 790,459 мянгад хүрч өмнөх оноос 3,2 хувиар буюу 24,5 мянган зорчигчоор нэмэгдсэн.

График 4-2: Олон улсын зорчигч тээвэрлэлт /2006-2016 он/





Дотоодын агаарын тээвэрлэгчдийн олон улсад тээвэрлэсэн зорчигчийн тоо- графикаар



График 4-3: “МИАТ”ХК- Олон улсын зорчигч тээвэрлэлт-/2011-2016 он/






График 4-4: “Аэромонголиа”ХХК- Олон улсын зорчигч тээвэрлэлт /2011-2016 он/








График 4-5: “Хүннү Эйр”ХХК- Олон улсын зорчигч тээвэрлэлт /2012-2016 он/



Гадаадын агаарын тээвэрлэгчдийн зорчигчийн тоо- графикаар




График 4-6: Гадаадын агаарын тээвэрлэгчдийн зорчигчийн тоо /2011-2016 он/





Агаарын тээвэрлэгчдийн олон улсын зах зээлд эзлэх хувь




Олон улсын зорчигч тээвэрлэлт, чиглэл тус бүрээр

Олон улсад 2016 онд нийт 17 чиглэлд зорчигч тээвэрлэснээс Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар чиглэлд хамгийн их буюу 302,919 зорчигч нийт зорчигчийн 38 хувь нь зорчсон байна.

Тус чиглэлд 2 агаарын тээврийн компани нислэг үйлддэг бөгөөд “МИАТ” ХК 46 хувийг, “Кореан Эйр” 54 хувийн зорчигчийг тээвэрлэсэн байна.

График 4-7: Аялалын тоо - /2016 оныг өмнөх онтой харьцуулсан хувиар






Олон улсын ачаа, шуудан


Олон улсын ачаа тээвэрлэлтийн хувьд 2015 онд өмнөх оноос 15 хувиар буурсан үзүүлэлттэй байсан бол 2016 онд олон улсад 4,363 тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 185 тонноор 4 хувиар өссөн байна.

График: 4-8: Олон улсын ачаа тээвэрлэлт - тонн /2006-2016 он/



Олон улсын шуудан тээвэрлэлтийн хувьд сүүлийн 4 жилийн байдлаар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2016 онд олон улсад 360 тонн шуудан тээвэрлэсэн бөгөөд өмнөх оноос тээвэрлэсэн шуудан 15 хувиар буурсан байна.

График 4-9: Олон улсын шуудан тээвэрлэлт - тонн /2006-2016 он/




ОРОН НУТГИЙН АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Орон нутгийн зах зээлийн хувьд “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК нь хуваарьт болон хуваарьт бус арилжааны нислэг гүйцэтгэсэн. Мөн ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгч болох “Блу Скай Авиэйшн” ХХК, “А-Жет Авиэйшн” ХХК, “Томас Эйр” ХХК, “Геосан” ХХК, “МАК” ХХК, “Парго Авиэйшн” ХХК тус тус хуваарьт бус нислэг үйлдсэн.

2016 онд орон нутгийн чиглэлд хуваарьт болон хуваарьт бус нийт 4,956 нислэг үйлдэж 232,586 зорчигч тээвэрлэсэн байна. Үүнээс “МИАТ” ХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК нь голлох үүргийг гүйцэтгэсэн ба Ховд, Улаангом, Өлгий, Даланзадгад, Оюутолгой, Мөрөн, Чойбалсан, Улиастай, Овоот, Алтай, Тавантолгой, Баянхонгор чиглэлд тогтмол нислэг үйлдсэн.

Орон нутгийн чиглэлд “МИАТ” ХК орон нутгийн нийт зорчигчийн 37 хувийг, “Аэромонголиа” ХХК 25 хувийг, “Хүннү Эйр” ХХК 37 хувийг, бусад агаарын тээвэрлэгчид 1 хувийг тээвэрлэсэн байна. Орон нутгийн зорчигчийн тоо 2010 оноос 2012 он хүртэл жилд дунджаар 57 хувийн өсөлттэй байсан. Харин 2013 оноос эхлэн орон нутгийн зорчигч тээвэрлэлт буурсан бол 2016 онд орон нутгийн зорчигчийн тоо өмнөх оноос 22,5 хувиар буюу 42,643 зорчигчоор өссөн байна. Орон нутгийн чиглэлд нийт зорчигчийн 47,2 хувь нь хуваарьт нислэгийн, 52,8 хувь нь захиалгат нислэг буюу уул уурхайн чиглэлд үйлдэгдсэн байна.

График 5-1: Орон нутгийн агаарын тээврийн зах зээл /Агаарын тээвэрлэгч тус бүрээр/




Орон нутгийн зорчигч тээвэрлэлт, чиглэл тус бүрээр

Орон нутагт 2016 онд нийт 12 чиглэлд зорчигч тээвэрлэснээс уул уурхайн чиглэл болох Оюутолгойн чиглэлд хамгийн их буюу 122,916 зорчигч зорчсон байна. Энэ нь нийт зорчигчийн 38 хувийг эзэлж байна. Тус чиглэлд 3 агаарын тээврийн компани нислэг үйлддэг бөгөөд “МИАТ” ХК 69 хувийг, “Хүннү эйр” ХХК 19 хувийг, “Аэро Монголиа” ХХК 12 хувийн зорчигчийг тээвэрлэсэн байна. Орон нутгийн чиглэлийн нийт зорчигчийн 52,8 хувийг захиалгат нислэгийн буюу уул уурхайн чиглэлийн зорчигч эзлэж байгаа бөгөөд энэ чиглэлд “МИАТ” ХК, “Хүннү эйр” ХХК, “Аэро Монголиа” ХХК тус тус захиалгат нислэг үйлдсэн байна.


Уул уурхайн чиглэлийн Оюутолгой, Тавантолгой, Овоот чиглэлүүд нь орон нутгийн нийт зорчигч тээвэрлэлтэд 2012 онд 39 хувь, 2013 онд 34 хувь, 2014 онд 28 хувь, 2015 онд 49 хувь, 2016 онд Оюутолгой, Овоот чиглэлүүд дийлэнх хувийг буюу 52,8 хувийг тус тус эзэлж байсан байна.

График 5-2: Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн зах зээл /Чиглэл тус бүрээр/





ОРОН НУТГИЙН АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ /2016 он/





Орон нутгийн чиглэлийн зах зээлийн хуваарилалт Аймаг тус бүрээр -2016 он

- ✚ Ховдын чиглэлд нийт 20,632 зорчигч зорчсон. Үүнээс “Аэромонголиа” ХХК нийт зорчигчийн 37 хувийг буюу 7,554 зорчигч тээвэрлэж, “Хүннү Эйр” ХХК нийт зорчигчийн 55 хувийг буюу 11,381 зорчигч тус тус тээвэрлэсэн байна.
- ✚ Өлгийн чиглэлд нийт 20,223 зорчигч зорчсоноос “Аэромонголиа” ХХК нийт зорчигчийн 54 хувийг буюу 10,987 зорчигч тээвэрлэж, “Хүннү Эйр” ХХК нийт зорчигчийн 46 хувийг буюу 9,236 зорчигчийг тус тус тээвэрлэсэн байна.
- ✚ Улаангомьн чиглэлд нийт 13,602 зорчигч зорчсоноос “Аэромонголиа” ХХК нийт зорчигчийн 51 хувийг буюу 6,871 зорчигчийг тээвэрлэж, “Хүннү Эйр” ХХК нийт зорчигчийн 49 хувийг буюу 6,731 зорчигчийг тус тус тээвэрлэсэн байна.
- ✚ Даланзадгадын чиглэлд нийт 20,650 зорчигч зорчсон. Үүнээс “Аэромонголиа” ХХК нийт зорчигчийн 60 хувийг буюу 12,482 зорчигч тээвэрлэж, “Хүннү Эйр” ХХК нийт зорчигчийн 40 хувийг буюу 8,168 зорчигч тус тус тээвэрлэсэн байна.
- ✚ Мөрөнгийн чиглэлд нийт 10,413 зорчигч зорчсоноос “Аэромонголиа” ХХК нийт зорчигчийн 33 хувийг буюу 3,476 зорчигч тээвэрлэж, “Хүннү Эйр” ХХК нийт зорчигчийн 67 хувийг буюу 6,937 зорчигч тус тус тээвэрлэсэн байна.
- ✚ Улиастайн чиглэлд нийт 8,700 зорчигч зорчиж, үүний 859 зорчигч буюу 9 хувийг “Аэромонголиа” ХХК, 7,841 зорчигч буюу 91 хувийг “Хүннү Эйр” ХХК тус тус тээвэрлэсэн байна.
- ✚ Чойбалсан чиглэлийн нийт 7,489 зорчигчийг “Хүннү Эйр” ХХК тээвэрлэсэн байна.
- ✚ **Уул уурхайн чиглэл** болох Оюу толгойн чиглэлд нийт 122,916 зорчигч тээвэрлэсэн. Үүнээс “МИАТ” ХК нийт зорчигчийн 69 хувийг буюу 85,270 зорчигчийг тээвэрлэж, “Аэромонголиа” ХХК нийт зорчигчийн 12 хувийг буюу 13,983 зорчигч тээвэрлэж, “Хүннү Эйр” ХХК нийт зорчигчийн 19,3 хувийг буюу 23,663 зорчигч тус тус тээвэрлэсэн байна. Овоотын чиглэлд нийт 4,532 зорчигчийг “Хүннү Эйр” ХХК тээвэрлэсэн байна. Үүнээс харахад орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ авч буй зорчигчдын тоо, багтаамж нь уул уурхайн зориулалттай захиалгат нислэгээр үйлчлүүлсэн зорчигчдын тооноос хол ялгаагүй байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж бага байгааг харуулж байгаа юм.



Орон нутгийн ачаа, шуудан

Орон нутгийн ачаа, шуудан тээвэрлэлтийн хувьд 2015 онд ачаа өмнөх оноос 50 хувиар, шуудан 28 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байсан бол 2016 онд 46 тонн ачаа, 83 тонн шуудан тээвэрлэсэн бөгөөд өмнөх оноос тээвэрлэсэн ачаа 34 хувиар өсөж, тээвэрлэсэн шуудан 8 хувиар буурсан байна.

График 5-3: Орон нутгийн чиглэлд тээвэрлэсэн ачаа - /Тонн/ -2006-2016 он





График: График 5-4: Орон нутгаг чиглэлд тээвэрлэсэн шуудан / /Тонн/ - 2006-2016 он



АГААРЫН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хуваарьт нислэг гүйцэтгэж буй үндэсний 3 агаарын тээвэрлэгчийн 2016 оны нийт үзүүлэлт - /Өмнөх онтой харьцуулсан хувиар/

2016/2015 ОН	Гүйцэтгэсэн зорчигч километр	▲ +3%	Гүйцэтгэсэн тонн километр	▲ +3%
	Боломжит суудал километр	▲ +4%	Аяллын тоо	▲ +9%

Гүйцэтгэсэн зорчигч километр - /2016 оныг өмнөх онтой харьцуулсан хувиар/

График 6-1:




График 6-2:



Боломжит суудал километр - /2016 оныг өмнөх онтой харьцуулсан хувиар/

График 6-3:





График 6-4:



Аялалын тоо - /2016 оныг өмнөх онтой харьцуулсан хувиар/

График 6-5:





График 6-6:



Гүйцэтгэсэн тонн километр - /2016 оныг өмнөх онтой харьцуулсан хувиар/

График 6-7:




График 6-8:



ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН АГААРЫН ТЭЭВЭР

Монгол Улсын Зам Тээврийн Хөгжлийн Сайдын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн №70 “Бүтэц, орон тоо батлах тухай” тушаалаар Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх нэгж анх удаа батлагдан, Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.119-р зүйл болох “Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана”-г хангах зорилготой ажиллаж байна.





Ерөнхий зориулалтын агаарын тээврийн тодорхойлолтууд

Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын тодорхойлолт:
Хуваарьт болон хуваарьт бус агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад бүх иргэний агаарын төлбөрт эсвэл түрээсийн үйл ажиллагаа

Холбооны нисэхийн удирдлага /FAA/-ын тодорхойлолт:
Иргэний агаарын тээврийн хуваарьт хуваарьт бус агаарын тээврийн үйлчилгээ болон арилжааны үйл ажиллагааны хэсэгт багтахгүй бусад нислэг

Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Хавсралт-6, 1-р бүлэгт:
Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа гэж– арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад агаарын хөлгийн үйл ажиллагаа эсвэл агаарын ажил хийх, үйл ажиллагааг хэлнэ.

Хүснэгт 7-1: Монгол улсын Ерөнхий зориулалтын агаарын тээвэрт одоо ашиглагдаж буй агаарын хөлөг /2016 он/

№	Агаарын хөлгийн зураг	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Бүртгэсэн огноо	Үйлдвэрлэсэн огноо	Үйлдвэрлэгч
МАК ХХК						
1		Ми-8АМТ	JU-6601	08.03.04	08.02.24	Ulan-Ude aviation Plant
2		Ми-8АМТ	JU-6600	11.10.13	11.10.10	Миль, ОХУ
А-Жет Авиэйшн ХХК						
3		EC145 helicopter BK117 variant C-2	JU-5598	11.10.28	09.01.06	Eurocopter Deutschland
4		EC145 helicopter BK117 variant C-2	JU-5499	12.08.08	09.03.17	Eurocopter Deutschland
Геосан ХХК						
5		CESSNA 208B	JU-9991	07.07.05	07.04.23	CESSNA Aircraft Company, USA
6		CESSNA 208B	JU-9993	09.06.29	09.04.23	
Блю Скай Авиэйшн						
7		CESSNA 208B	JU-2114	11.04.21	99.10.28	CESSNA Aircraft Company, USA
Флай Адвенчур ХХК						
8		Бекас X-32-912	JU-9090	10.03.09	10.01.25	Украина, Лилиенталь
Томал Эйр ХХК						
9		Maule M-7 235c	JU-1919	12.03.21	11.05.14	Maule Aerospace
10		Airtractor AT-602	JU-1918	12.07.04	10.04.16	AirtractorInc
Парко Авиэйшн ХХК						
11		EV-97 Eurostar	JU-9077	12.06.29	11.09.16	EvectorAerotechnik
Goldvest Enterprises						
12		Ан-2	JU-9069	13.04.26		PZL Mielec, Poland
Сэлиэр Авиэйшн Монголиа ХХК						
13		Xenon 4	JU-9009	16.04.13	14.06.01	Celier Aviation Sp.ZO.O
ТопЭкстримЭкшнМонголиа ХХК						
14		MTO Sport	JU-9001	14.03.18	12.01.20	AutoGyro GmbH
15		MTO Sport	JU-9002	14.03.18	12.06.18	AutoGyro GmbH
16		Calidus	JU-9003	16.04.13	15.06.12	AutoGyro GmbH
17		Cavalan	JU-9005	16.04.13	15.09.18	AutoGyro GmbH

Америкийн нэгдсэн улсын ерөнхий зориулалтын агаарын тээврийн тухай мэдээлэл

2015 оны байдлаар дэлхийн хэмжээнд 362 мянган ерөнхий зориулалтын агаарын хөлөг байгаа ба үүний 204 мянга нь АНУ-д байдаг бөгөөд ангилан авч үзвэл, 2 хүний суудалтай сургалтын болон тив алгасаж нисэх чадвартай бизнес ангиллын агаарын хөлгүүд эзэлж байгаа ба нийт агаарын хөлгийн 56%-г дангаараа бүрдүүлж байна. Дийлэнх нислэгийг бизнесийн чиглэлийн нислэг эзэлж байна. 2016 оны байдлаар дэлхий дахинд ерөнхий зориулалтын агаарын тээврийн зах зээлд хамгийн их борлуулагдаж байгаа агаарын хөлгөөр Ce-172s Skyhawk SP(142ш), хамгийн их үйлдвэрлэгдсэн агаарын хөлгөөр Cessna aircraft (539ш) үйлдвэрлэсэн ба тухайн жилд дэлхийн хэмжээнд уг салбарын орлого нь 24,12 тэрбум.доллар байсан байна. 2016 онд уг салбараас дэлхийн хэмжээнд олсон орлого нь 24,1 тэрбум доллар байгаа бол дэлхийн хэмжээнд агаарын хөлгийн дундаж үнэ 10,3 сая доллар байна.

Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн үйлдвэрлэл, тэдгээрийн ашиглалтыг бүс нутгаар доорх графикаас харна уу.

График 7-1: Сэнст хөдөлгүүрт




График 7-2: Поршинт хөдөлгүүрт





График 7-3: Тийрэлтэд хөдөлгүүрт



Дээрхи үзүүлэлтээс харахад ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нийт ашиглалт болон худалдааны 63,1%-г Хойд америк эзэлж байна. Дэлхийн хэмжээнд нийт 2,331 агаарын хөлөг зарагдсан бол АНУ дангаараа 1,592 агаарын хөлгийг борлуулжээ. АНУ-ын хэмжээнд одоогийн байдлаар 5000 гаруй улсын болон хувийн нисэх буудал үйл ажиллагаагаа явуулж байна. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн холбооноос гаргасан мэдээллээс иш татвал, ерөнхий зориулалтын салбарт АНУ жилд 219 тэрбум.долларын хувь нэмэр улсынхаа төсөвт оруулж 1,1 сая хүнийг ажлын байраар хангаж байгаа нь улсынхаа эдийн засагт томоохон хувь нэмрийг оруулж байна. Түүнчлэн, жил болгон 23 сая цагийн нислэг үйлдэж байна гэсэн тооцоо судалгаа гарчээ.

Хүснэгт 7-2: Бага оврын агаарын хөлгийн нийлүүлэлт /бүс нутгаар, 2007-2016 он %-р/

Жил	Поршинт хөдөлгүүрт					Сэнст хөдөлгүүрт					Тийрэлтэт хөдөлгүүрт				
	Хойд Америк	Европ	Ази номхон далай	Латин Америк	Зүүн Африк	Хойд Америк	Европ	Ази номхон далай	Латин Америк	Зүүн Африк	Хойд Америк	Европ	Ази номхон далай	Латин Америк	Зүүн африк
2010	53.4	18.6	13.7	8.8	5.5	43.2	15.2	16.8	14.7	10.1	42.1	22.8	11.8	14.3	9
2011	57.7	12	15.6	10	4.6	52.6	14.1	14.4	13.6	5.3	50	20.2	12.9	10.1	6.8
2012	50.4	19.6	16.3	9.7	4.1	48.6	12.6	17.4	14.5	6.9	49.7	20.8	11.8	11.6	6.1
2013	52.8	17.2	15.1	10	5	57.1	10.5	14	13.2	5.3	52.4	15.6	11.9	11.1	9
2014	55.1	19.7	12.1	8.9	4.3	51.3	7.7	19.4	15.3	6.3	52.2	19.5	10.9	9.4	7.9
2015	66.7	11.4	13.5	6.3	2.2	56.2	6.6	16.3	14.5	6.3	60.8	18	9.2	7.1	4.9
2016	69.6	10.1	10.2	5.8	4.3	57.8	10.6	13.2	9.9	8.4	62	18.8	7.7	6.2	5.3

Эх сурвалж: General Aviation Manufacture Association , 2016



ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИД



“Монголын Алт” /МАК/ ХХК-ийн Нисэх газар нь 2007 оны 6 дугаар сарын 22-нд байгуулагдсан. Ми-8АМТ загварын 2 ширхэг агаарын хөлгөөр үйлчилгээ явуулдаг

- Захиалгат нислэг
- Аялал жуулчлал
- Геологи уул уурхай
- Ачаа тээвэрлэлт
- Түргэн тусламж
- Дүүжин тээвэр



“Cessna-208В” загварын 2 ширхэг агаарын хөлгөөр үйлчилгээ явуулдаг

- Захиалгат нислэг
- Түргэн тусламжийн нислэг
- Аялал жуулчлалын нислэг

Хээрийн нислэгийн зурвас нээх үйлчилгээ



“EC-145 МВВ-ВК117 – С2” загварын 2 ширхэг агаарын хөлгөөр үйлчилгээ явуулдаг

- Зорчигч
- Геологи хайгуул
- Эрэн хайх
- Агаараас зураг авах
- Түргэн тусламж
- Ачаа тээш
- Уул уурхай
- Авран туслах
- Шүхрийн нислэг

Онцгой болон тусгай үүргийн нислэгүүд



“Тэнгэрийн улаач шинэ” ХХК нь Л-410 УВП загварын 1 ширхэг агаарын хөлгөөр үйлчилгээ явуулдаг

- Хуваарьт нислэг
- Ачаа тээвэрлэлт
- Түргэн тусламж
- Онцгой, тусгай үүргийн нислэг
- Хээрийн нислэгийн зурвас нээх үйлчилгээ
- Шүхэрчид буулгах
- Захиалгат нислэг
- Аялал жуулчлал
- Геологи уул уурхай
- Шалгалтын нислэг



2016 оноос “Вельгаль-Авиа Стар” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Ан-2 маягийн агаарын хөлгөөр:

- Хөдөө аж ахуйн зориулалттай
- Шүхэр хаях нислэг
- Түргэн тусламжийн
- Захиалгат нислэг
- Агаараас зураг авах
- Эрэн хайх авран хамгаалах нислэг үйлдэж байна



“Геосан” ХХК нь геологи, уул уурхайн салбарт 20 жил, агаарын тээвэрт 10 жил агаарын болон газрын геофизикийн судалгаа, геодези, агаарын фотограмметрийн хэмжилт, боловсруулалт, зорчигч, ачаа тээвэрлэлт, дадлага сургалт, түргэн тусламж, захиалгат нислэг зэрэг үйл ажиллагаа явуулж байна



“Томас Эйр” компани нь 2011 оны 6-р сараас нислэгийн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар Maule М7 – 235С, Airtractor АТ-602 загварын 2 ширхэг агаарын хөлгөөр үйлчилгээ үзүүлж байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн зориулалт бүхий авиацигийн нислэг
- Байгаль хамгаалах авиацигийн нислэг
- Түр аэродром сонгох, гэрчилгээжүүлэх зөвлөгөө өгөх үйлчилгээ



“Топ Экстрим Экшн Монголиа” ХХК нь МТО Sport загварын 2 ширхэг, Calidus загварын 1 ширхэг, Cavalon загварын 1 ширхэг 4 агаарын хөлгөөр үйлчилгээ явуулдаг.

- Аялал жуулчлал
- Бараа тоног төхөөрөмжийн худалдаа, зуучлал
- Агаарын болон усан спортын чиглэл
- Нислэг сургалтын аюулгүй байдал



Eurostar EV-97, Sportstar загварын агаарын 2 ширхэг хөлөгтэй

- Нисгэгчийн сургалт
- Агаарын хөлгийн худалдаа
- Агаарын хөлгийн засвар үйлчилгээ хадгалалт
- Арилжааны нислэг
- Газрын үйлчилгээ

Нисэхийн бүх чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ









НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2016 онд Улаанбаатар хотын “Чингис Хаан” Олон улсын нисэх буудал болон орон нутгийн нийт 23 нисэх буудал үйл ажиллагаа явуулсан байна.



Эдгээр нисэх буудлуудын үйл ажиллагааг холбогдох үзүүлэлтүүдээр харуулбал:

1. Газар зүйн байрлалын хувьд:

-  Баруун бүс - 5
-  Хангайн бүс - 3
-  Төвийн бүс - 5
-  Зүүн бүс - 3
-  Түр зөвшөөрөлтэй нисэх буудал-4
-  Бүртгэлтэй нисэх буудал-4





Нийт 24 нисэх буудал

2. Үйл ажиллагааны хувьд:




-  Тогтмол үйл ажиллагаатай 20 нисэх буудал
-  Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг 4 нисэх буудал

3. Гэрчилгээ эзэмшигчийн хувьд:

ИНЕГ- 20

-  “Эй Си Эйч Сервис” ХХК-1
-  “Саусгоби Сэндс” ХХК-1
-  “Таван толгой нисэх буудал” ХХК-1
-  “Тэнгэрийн найзууд” ХХК-1


4. Хөөрч буух зурвасын гадаргуу:

-  Бетон хучилттай -5
-  Асфальт-бетон хучилттай-5
-  Шороон зурвастай- 14

5. Гэрэл суултын систем:

-  Гэрэл суултын системтэй-8

6. Аэродромын зэрэглэл:

-  4D- 1
-  4C- 2
-  3C- 20
-  1B-1



УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ

Одоогийн “Чингис Хаан” Олон улсын нисэх буудлын үйлчилгээнд тулгарч буй хүндрэлүүдийг арилгах, нисэхийн аюулгүй ажиллагааны хангалтыг дээшлүүлэх, агаарын тээвэрлэлтийг тогтворжуулах, Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигийн хөндийд “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийг Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Олон улсын стандартад нийцсэн нисэх онгоцны буудал барих төслийн зөвлөхөөр Япон улсын “Азуса Сэккэй/ Ориентал Консалтантс Глобал” түншлэл, Ерөнхий гүйцэтгэгчээр Япон Улсын “Мицүбиши-Чиёода” түншлэл, Ерөнхий туслан гүйцэтгэгчээр БНСУ-ын “Самсунг Си энд Ти” компани тус тус ажилласан.

Төслийн нийт 32 барилга, байгууламжийг хүлээн авах ажил явагдаж байна.

Дээрх зээлийн гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газрын хөрөнгөөр баригдах барилга байгууламжууд;

- 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам татах, дэд станц
- Интернет холбоо мэдээллийн шилэн кабел татах
- Үерийн хамгаалалтын далан
- Шинэ нисэх буудлыг Улаанбаатар хоттой холбох хурдны авто зам
- Аэродром засвар үйлчилгээний барилга
- Захиргааны барилга
- Ачаа шуудан, тээврийн үйлчилгээ барилга



Энэхүү төсөл хэрэгжснээр:


- ✚ Нисэх буудлын ашиглалт одоогийн байгаа 73%-иас 98%-д хүрнэ.
- ✚ Цаг агаарын тааламжгүй байдал, салхины чиглэлээс шалтгаалах нислэгийн саатлыг одоогийн байгаа 2.3%-ийг 0.5%-д болгоно. (1000 нислэгт 5 саатал хүртэл)
- ✚ Агаарын тээвэрлэлт дамжин өнгөрөлтийг нэмэгдүүлнэ.
- ✚ Нисэхийн аюулгүй ажиллагааны хангалтыг сайжруулж шинэ нисэх буудал нь агаарын хөлгийн нислэгийн хоёр талын буулт, хөөрөлт хийх боломжийг бүрдүүлэх юм.

АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Нислэгийн хөдөлгөөн удирдах газар нь Монгол Улсын агаарын зайн бүтэц, ангилал, зохион байгуулалтыг бодлого ба үйлдвэрлэлийн хүрээнд удирдан зохион байгуулж, нислэгийн аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Монгол Улсын агаарын зайн ангилал нь ИНД 71-ийн дагуу А,В,С,Д,Е,Ғ,Г гэсэн 7 ангилалд хуваагдах боломжтой ба одоогоор А,С,Д,Г гэсэн 4 ангилал ашиглагдаж байна. Монгол улсын агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлөгт агаарын навигацийн цогц үйлчилгээг 24 цагийн турш тасралтгүй үзүүлж байна.

АГААРЫН ЗАЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




15
АГААРЫН
ХААЛГА

52
АГААРЫН
ЗАМ


5 БҮСИЙН
УДИРДАГЫН
СЕКТОР

15 НИСЭХ БУУДЛЫН
ОЙРТОЛЫН БА АЭРОДРОМЫН
УДИРДЛАГЫН БҮС

Ажиглалтын системийн хөгжлийн үе шатууд



Ажиглалтын радиолокаторийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ADS-B автомат хамааралтай ажиглалтын системийг мөн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн 1 дугаар үе шат амжилттай хэрэгжин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд нөхцөл байдлыг таних зорилгоор ашиглаж эхэлсэн.



Монгол Улсын агаарын зайд үйлдэгдсэн нислэгийн тойм

Монгол Улсын агаарын зайгаар 2016 онд өнгөрөлтийн нийт 99,210 нислэг, 6,726 олон улсын буулт, хөөрөлт, 4,956 орон нутгийн буулт, хөөрөлт үйлдэгдсэн ба өнгөрөлтийн нислэгийн тоо өмнөх оноос 9,4 хувиар өсөж, олон улсын буулт, хөөрөлт өмнөх оноос 4.6 хувиар, орон нутгийн буулт, хөөрөлт 8,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

График 9-1: Олон улсын буулт, хөөрөлтийн тоо /2010-2016 он/




График 9-2: Орон нутгийн буулт, хөөрөлтийн тоо /2010-2016 он/






График 9-3: Өнгөрөлтийн нислэг /2010-2016 он/






График 10-3: Монгол улсад импортоор орж ирсэн агаарын хөлгийн шатахууны хэмжээ /тонн/



Манай улсад импортоор орж ирсэн агаарын хөлгийн шатахууны хэмжээ 2016 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотоос орон нутгийн нисэх буудлууд руу жилд 900 тонн шатахуун тээвэрлэдэг бөгөөд үүнээс Баруун бүсийн нисэх буудлууд руу дийлэнх хувийг тээвэрлэж байна.

График 10-4: Орон нутгийн нисэх буудлууд руу тээвэрлэсэн шатахууны хэмжээ /тонн/





ТӨСӨӨЛӨЛ

1995 оноос 2016 он хүртлэх тээвэрлэлтийн үзүүлэлтүүдийн жигнэсэн дундаж өсөлтөөр зорчигч, ачаа, шуудангийн ирээдүйн төсөөллийг тооцоолов. Олон улсын зорчигч тээвэрлэлтийн жигнэсэн дундаж өсөлт 6,6 хувиар, орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн жигнэсэн дундаж өсөлт 5,4 хувиар, олон улсын ачаа шуудан тээвэрлэлтийн жигнэсэн дундаж өсөлт 5 хувиар, орон нутгийн ачаа, шуудан тээвэрлэлтийн жигнэсэн дундаж өсөлт 7 хувиар тус тус өссөн өсөлтөөр 2030 он хүртэл төсөөлөв.

График 11-1: Олон улсын зорчигч тээвэрлэлтийн төсөөлөл /1995-2030 он/




График 11-2: Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн төсөөлөл /1995-2030 он/




График 11-3: Олон улсын ачаа шуудангийн төсөөлөл /1995-2030 он/





График 11-4: Орон нутгийн ачаа шуудангийн төсөөлөл /1995-2030 он/





МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ /2010-2016 ОН/

Хүснэгт 12-1

Тээврийн үзүүлэлтүүд	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	<u>2016 он</u> <u>2015 он</u>
Тээсэн ачаа /мян.тонн/								
Бүгд	29,415.8	44,085.9	53,348.1	42,557.3	44,636.2	35,828.9	40,336.1	13%
Төмөр замын тээвэр	16,804.0	18,447.7	20,445.2	21,035.5	21,118.6	19,143.9	19,927.0	4%
